

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН
2024 ОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.02.24

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Зам, тээврийн сайд, аймгуудын Засаг дарга нарын 2024 оны хамтын ажиллагааны гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, орон нутгийн Засаг дарга нарыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны хамтын ажиллагааны гэрээний зорилго нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн зам, тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, хүн амын амьдралын таатай нөхцөлийг хангах, иргэдийн ая тухтай зорчих боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү гэрээгээр Зам, тээврийн сайд зам, тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн үйл ажиллагаанд салбарын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар орон нутагт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн ба аймгийн Засаг дарга нар авто зам, автотээвэр, агаарын тээвэр, төмөр зам, усан замын тээврийн чиглэлээр тодорхой үүргүүдийг хүлээсэн байна.

Зам, тээврийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны хамтын ажиллагааны гэрээнд нийт 480 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 211, 90 хувийн биелэлттэй 46, 70 хувийн биелэлттэй буюу үр дүн гарсан 38, 50 хувийн биелэлттэй 16, 30 хувийн биелэлттэй 73, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 51, гэрээгээр төлөвлөсөн боловч үнэлгээнд тооцох боломжгүй 45 арга хэмжээний дундаж үнэлгээ **71.0** хувьтай байна.

Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг аймаг тус бүрээр авч үзвэл:

№	Аймаг	Нийт	Үнэлгээ /хувиар/						ҮБ	ХШҮ хувь
			100	90	70	50	30	0		
1	Архангай	19	10	1	-	-	5	2	1	68.9
2	Баян-Өлгий	23	12	5	2	1	-	3	-	80.0
3	Баянхонгор	19	9	2	2	-	1	5	-	65.8
4	Булган	23	11	-	1	-	4	3	4	67.9
5	Говь-Алтай	24	7	5	1	2	3	3	3	67.1
6	Говьсүмбэр	21	11	3	1	-	3	1	2	80.5
7	Дархан	21	15	4	-	-	1	1	-	90.0
8	Дорноговь	19	9	2	2	-	4	1	1	74.4
9	Дорнод	29	15	-	4	2	7	1	-	72.1
10	Дундговь	23	8	2	4	1	4	2	2	68.1
11	Завхан	23	10	2	1	1	3	4	2	66.2
12	Орхон	19	10	2	-	-	1	-	6	93.1
13	Өвөрхангай	21	6	1	4	1	3	3	3	61.7
14	Өмнөговь	26	10	1	-	1	5	3	6	64.5
15	Сүхбаатар	23	7	-	1	1	4	4	6	55.3
16	Сэлэнгэ	25	13	-	3	-	8	-	1	72.9
17	Төв	23	11	4	2	1	2	1	2	81.4
18	Увс	23	7	2	3	3	1	4	3	63.5
19	Ховд	26	7	5	4	1	3	4	2	65.4
20	Хөвсгөл	22	12	-	1	1	5	3	-	66.8
21	Хэнтий	28	11	5	2	-	6	3	1	69.3
Нийт		480	211	46	38	16	73	51	45	71.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Зам, тээврийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.0 функтээр үнэлгээ буурсан байна. 2024 онд хамтран ажиллах гэрээний хамгийн сайн үнэлэгдсэн аймгаар Орхон аймаг 93.0 хувиар үнэлэгдсэн бол Сүхбаатар аймаг хамгийн бага буюу 55.3 хувиар үнэлэгдсэн байна.

3.1. Авто замын чиглэлээр:

3.1.1. Авто замын чиглэлээр хамтран ажиллах гэрээнд авто замын чиглэлээр аймаг тус бүр харилцан адилгүй байдлаар буюу Дорноговь аймаг 3 арга хэмжээ, Орхон аймаг 4 арга хэмжээ, бусад аймгууд 5-6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн байна.

3.1.2. “Нутгийн зам дэд хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх заалт зарим аймгийн гэрээнд тусаагүй, “Унадаг дугуйн зорчих орчин ба хэрэглээг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй зөрчил илэрсэн байна. Мөн 4.2.6 “Шинэ сэргэлтийн таван тойрог төсөл”-ийг хэрэгжүүлэхэд орон нутгаас бүх талаар дэмжлэг үзүүлж хамтран ажиллах арга хэмжээ нь нийтлэг байдлаар зам, тээврийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтийг дүгнээгүй, зөвхөн авто замын чиглэлд тусгасан байна.

3.1.3. “Авто замын тухай хууль”-ийн 16.6 дугаар заалтад “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газарт газар өмчлүүлэхийг хориглох бөгөөд газар түр эзэмшүүлэх асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ” гэж заасны дагуу олон улс, улсын чанартай авто замын зурвас газрыг баталгаажуулах ажлыг эрчимжүүлэхэд яам болон орон нутгийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна. Гэрээнд зааснаар “Улсын чанартай хатуу хучилттай авто замын зурвас газрыг тус яаманд эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум орон нутгийн 2024 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулж, эзэмшүүлэх асуудлаар хамтран ажиллах” арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.4. “Эрх шилжсэн авто зам, гүүрийн барилгын ажлын явцын талаарх мэдээ, мэдээллийг 7 хоног бүр цахим шуудан болон бусад мэдээллийн хэрэгслээр, сарын мэдээ тайланг зөвлөх байгууллагаар баталгаажуулан албан бичгээр ирүүлэх” арга хэмжээг дүгнэхэд яам болон АЗЗА байгууллагууд аймгийн тамгын газруудын хамтын ажиллагааг сул байгааг харуулж байна.

3.2. Авто тээврийн чиглэлээр:

3.2.1. Авто тээврийн чиглэлээр хамтран ажиллахаар аймаг тус бүр харилцан адилгүй байдлаар буюу 6-8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.2.2. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд орон нутгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн төлөвлөгөөнд суурилсан дэд төлөвлөгөөг батлан, арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээг Хэнтий аймаг хэрэгжүүлсэн ч цаг хугацаа, тоо баримттай тайлагнаагүй байна. Бусад аймгууд аймгийн Замын Цагдаа болон орон нутгийн автотээврийн улсын байцаагч нартай хамтран ажилласан тухай тайлагнасан байна.

3.2.3. “Орон нутгийн онцлогийг харгалзан цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 1-ээс дээш, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц 2-оос доошгүйг 2024 онд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж ашиглах, олон нийтэд сурталчлах арга хэмжээ авах, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр яаманд мэдэгдэх” арга хэмжээний хүрээнд аймгууд хувийн аж ахуй нэгж байгууллага санал гараагүй тул цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 1-ээс дээш, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц нэмэгдээгүй тухай тайлагнасан байна. Энэ нь тус арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх шалтгаан болсон ба аймгийн зүгээс шаардлагатай станцуудыг барьж байгуулснаар цахилгаан болон хийгээр ажилладаг автомашины хэрэглэлээ нэмэгдэх, агаар, орчны бохирдол буурах зэрэг эерэг үр дүн гаргаж ажиллах боломжтой байсан байна.

3.2.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээн авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж ажиллах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр яамнаас нэгдсэн бодлого, арга зүйн зөвлөмжөөр хангаагүй байна. Тус арга хэмжээний талаар 21 аймагтай уулзалт хийх, дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад манлайлан чиглүүлж ажиллах шаардлагатай байна.

3.2.5. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замаар даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж байгаа тээвэрлэлтэд хяналт тавих, даац хэтрэлтээс авто замд учруулах хохирлыг барагдуулах, таслан зогсооход хамтран ажиллах арга хэмжээг Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудаас бусад 18 аймаг төлөвлөгөөгүй байгаа нь

“Тээврийн хэрэгслийн техникийн нөхцөлд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020 стандарт 5.1.18 дахь хэсэгт зааснаар бүх жин нь 44 тонноос их ачаа ачсан тээврийн хэрэгслийн даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж буй үйл ажиллагааны хяналт сул байгааг харуулж байна. Энэ нь Олон улс, улсын чанартай авто замын эвдрэлийн гол шалтгаануудын нэг болж байна.

3.3. Агаарын тээврийн чиглэлээр:

3.3.1. Хамтран ажиллах гэрээнд 2-7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээлсэн ба Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг улсын тусгай хэрэгцээний газарт авах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-д заасны дагуу эрхий бүхий байгууллагын шийдвэр гаргуулах шаардлагатай байна.

3.3.2. Агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах; Монгол Улсын Их хурлын 2022 оны 72 дугаар тогтоол болон Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолд тус тус даалгасны дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн харьяа иргэнд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг аймгийн 2024 оны төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг нийтлэг байдлаар 21 аймгийн гэрээнд тусгасан нь орон нутгийн нислэг сэргээгүй буюу байнгын нислэг үйлдэгдэх боломжгүй аймгуудад хэрэгжих боломжгүй заалт юм. Энэ нь 21 аймгаас гэрээ байгуулах санал авахдаа аймгууд зам, тээврийн салбарын хэмжээнд бус авто зам, автотээврийн салбарт ач холбогдол өгч байгааг нь гэрээний хэрэгжилтийн үнэлгээ буурах гол шалтгааны нэг болсон байна.

3.4. Төмөр замын чиглэлээр:

3.4.1. Хамтран ажиллах гэрээнд аймаг тус бүр 2-7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээнд тусгагдсан ба эдгээр арга хэмжээг тухай орон нутгийн онцлогт тохируулан төлөвлөх нь зүйтэй байна.

3.4.2. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт баруун зүүн, босоо тэнхлэгийн дагуу төмөр замын сүлжээ байгуулахаар тусгагдсан. Энэ нь шинээр төмөр замын бүтээн байгуулалт хийхээр төлөвлөж буй аймгийн удирдлагын зүгээс хийх арга хэмжээг тодорхой тусгаагүй бөгөөд нийтлэг байдлаар төлөвлөсөн нь төмөр замын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх гол шалтгаан болсон байна.

3.5. Усан замын тээврийн чиглэлээр:

3.5.1. Усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавих чиглэлээр хамтран ажиллахаар Архангай, Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын гэрээнд 2-4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээнд тусгасан байна.

3.5.2. Усан тээврийн хяналтын чиглэлээр томоохон, гол, мөрөн, нуур ихтэй орон нутагт тээврийн аюулгүй байдлыг хангуулахад боловсон хүчин дутагдалтай, хөрөнгийн асуудлыг орон нутгийн тухай жилийн төсөвт суудаггүй, мөстөлт, гэсэлтийн үед ард иргэд анхааруулах, тэмдэг, тэмдэглэгээ, хил, зурвасыг хангалтгүй тогтоож байгаа дутагдалтай байна. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг аймгууд тоо баримтгүй,

дутуу дулимаг тайлагнах зэрэг зөрчил нь гэрээний хэрэгжилтийг дүгнэх явцад хүндрэл үүсгэж байна.

3.6. Салбарын хяналтын чиглэлээр:

3.6.1. Салбарын хяналт, шалгалтын чиглэлээр 21 аймгийн гэрээнд 2 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгасан байна.

3.6.2. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд, хяналт шалгалтыг зохион байгуулах салбарын улсын байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж хэвшсэн. Зам, тээврийн салбарын хяналт шалгалтын журам, аргачлал, зөвлөмжийн хэрэгжилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тайлагнах үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

3.7. Нийтлэг байдлаар:

3.7.1. Орон нутгийн захиргааны байгууллага нь зам, тээврийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг бага, уялдаа холбоогүй ажиллаж байгаа нь гэрээний хэрэгжилтээс харагдаж байна. Мөн гэрээнд тусгагдсан ажлыг зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй, биелэлт тоо баримтгүй, төлөвлөсөн арга хэмжээнээс зөрүүтэй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшингүй төлөвлөсөн. Энэ нь гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байгаа тул цаашид орон нутгийн зүгээс анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.7.2. Аймгууд гэрээний биелэлтээ заасан хугацаанд ирүүлдэггүй, хэрэгжүүлсэн арга хэмжээгээ бүрэн тайлагнадаггүй нь өмнөх оны гэрээний биелэлтийг үнэлж дүгнээгүй байхад дараа оны гэрээг байгуулснаар гэрээнд тусгах шаардлагагүй болон бүрэн хэрэгжсэн арга хэмжээг дахин төлөвлөсөн, яамны бодлого зохицуулалтын газрууд нийтлэг байдлаар гэрээнд санал тусгаж байна. Энэ нь жил бүр гэрээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх гол шалтгаан болсоор байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1. Зам, тээврийн сайд, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тухайн аймгийн нийгэм, эдийн засгийн зорилт, орон нутгийн байршил, цаг агаар зэрэг онцлог шинжтэй уялдуулан гэрээг төлөвлөх, төлөвлөгөөний төслийг бодлого зохицуулалтын газруудад танилцуулах санал, зөвлөмжийг тусгаж байхыг ТЗУГ анхаарах;

4.2. 21 аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээг боловсруулахдаа суурь түвшин, зорилтод түвшинг тогтоох, бодлого зохицуулалтын газрууд гэрээний хэрэгжилтийг улирал бүр үнэлүүлж, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө, дэмжлэгийг аймгуудад үзүүлэх, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр ажиллахыг бодлого, зохицуулалтын газруудад;

4.3. Улсын чанартай хатуу хучилттай авто замын зурвас газрыг тус яаманд эзэмшүүлэх судалгааг хийх, аймаг, сум орон нутгийн 2025 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд улсын чанартай хатуу хучилттай авто замын зурвас газрыг тус яаманд эзэмшүүлэх талаар тусгуулж, орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллагааг уялдуулан ажиллахыг АЗБЗГ-т;

4.4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд орон нутгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн төлөвлөгөөнд суурилсан дэд төлөвлөгөөг батлан, арга хэмжээг хэрэгжүүлэх”, “Орон нутгийн онцлогийг харгалзан цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 1-ээс дээш, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц 2-оос доошгүйг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах”, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээн авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж ажиллах” зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон, хэрэгжилт хангалтгүй байгаа аймгуудын “Автотээврийн үндэсний төв”-д анхааруулах, арга хэмжээ авч ажиллахыг АТБЗГ-т,

4.5. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг улсын тусгай хэрэгцээний газарт авах арга хэмжээг зохион байгуулах, “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-д заасны дагуу эрхий бүхий байгууллагын шийдвэр гаргуулах, орон нутгийн нисэх буудлууд болон 21 аймгуудын захиргааны байгууллагатай хамтран ажиллах, 21 аймгийн гэрээ байгуулахад аймаг бүрийн онцлогийг зааглан гэрээнд арга хэмжээг тусгуулж байхыг Иргэний нисэхийн бодлого, зохицуулалтын газарт;

4.6. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг” болон бусад бодлогын баримт бичигт туссан шинээр төмөр замын бүтээн байгуулалт хийхээр төлөвлөж буй аймгийн зүгээс хийх арга хэмжээг тодорхойлон гэрээнд санал өгөх, гэрээнд төмөр замын чиглэлээр туссан арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газарт;

4.7. Орон нутгийн хэмжээнд, хяналт шалгалтыг зохион байгуулах, салбарын улсын байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж арга хэмжээний заалтыг нарийвчлан гэрээнд тусгуулах санал өгч, хэрэгжилтийг дүгнэж ажиллахыг Салбарын хяналтын газарт;

4.8. Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг тухайн оны 06 дугаар сарын 15-ны өдөр болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гэрээний биелэлтийг үнэлүүлж байх, гэрээ байгуулахаас өмнө гэрээ дүгнэх хурлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

4.9. Зам, тээврийн сайд, 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн санал, зөвлөмжийг биелэлтэд үнэлгээ өгөх, тус үнэлгээ нь яамны нэгжүүдийн үйл ажиллагааг дүгнэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг болгон ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт;

4.10. Гэрээний биелэлтийг төлөвлөсөн арга хэмжээний агуулга, дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнг зөв бичих дүрмийн алдаагүй, товч бөгөөд тодорхой, цаг хугацаа, тоо баримттай тайлагнаж байхыг тус тус зөвлөж байна.

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ НАР ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 2021-2024
ОНД ХАМТРАН АЖИЛЛАХААР БАЙГУУЛСАН “САНАМЖ БИЧИГ”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй:

Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тус тус баримтлан ажиллав.

Хоёр. Танилцуулга:

Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний 5 зорилтын 21 арга хэмжээний дундаж хэрэгжилт **80.0** хувь байна.

“Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт тус бүрээр авч үзвэл:

/Хүснэгт 1/

№	Зорилт	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ
			100	90	70	50	30	0		
1	1-р зорилт	5	-	2	2	1	-	-	-	74.0
2	2-р зорилт	6	4	-	1	1	-	-	-	86.6
3	3-р зорилт	4	2	2	-	-	-	-	-	95.0
4	4-р зорилт	3	1	-	2	-	-	-	-	80.0
5	5-р зорилт	3	-	1	-	1	1	-	-	56.6
Нийт		21	7	5	5	3	1	-	-	80.0

“Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд 30-50 хувиар үнэлэгдсэн 4 арга хэмжээ байна. Үүнд:

/Хүснэгт 2/

№	Зорилт, дугаар	Төлөвлөсөн арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/
1	1.2.	Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох Наадамчдын гудамжны авто зам дээгүүр тавих 800 у/м гүүрийн барилгын ажлыг эхлүүлэх	50
2	2.3.	Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулна.	50
3	5.1.	Авто замын сүлжээний арчлалт, урсгал засварын ажлын төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох	30
4	5.3.	Авто замын төлбөр хураамж авах тогтолцоог шинэчлэх	50

“Санамж бичиг”-ийн төлөвлөгөөнд 5 зорилтын 21 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар Зам, тээврийн яамны 5 нэгж, харьяа 1 байгууллага, Нийслэлийн харьяа 11 байгууллага хамтран ажиллаж байна. Эдгээр нэгж, байгууллагуудын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг доорх хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 3/

№	Хариуцсан нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/						ХБ	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	АТБЗГ	12	7	3	2	-	-	-	-	92.5
2	АЗБЗГ	6	1	2	-	2	1	-	-	68.3
3	ТЗДТБЗГ	2	1	1	-	-	-	-	-	95.0
4	СХГ	1	1	-	-	-	-	-	-	100.0
5	МТХ	2	-	-	1	-	-	-	1	70.0
6	АТҮТ	5	1	1	2	1	-	-	-	76.0
7	Нийслэл	21	6	6	4	2	3	-	-	76.7

Гурав. Үнэлэлт, дүгнэлт:

3.1. Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт **80.0** хувиар үнэлэгдлээ.

3.2. Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь байгууллагуудын чиг үүрэгт нийцүүлээгүй, ажлын ялгаа, заагийг тодорхойлж төлөвлөөгүйн улмаас хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл үүсч, энэ нь хэрэгжилт хангалтгүй дүгнэгдэх гол шалтгаануудын нэг болсон байна.

3.3. Нийслэлийн харьяа байгууллагын олон газар нэг ажил, үйлчилгээг хамтран хэрэгжүүлж байгаа нь зарим арга хэмжээний биелэлт дутуу, нэг газар дангаар тайлагнах зэрэг алдаа дутагдалтай байна. Мөн “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хариуцан ажиллаж буй яамны албан хаагчид нийслэл хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл дутмаг байна. Иймд “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэгч талууд хийж буй төсөл, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр хангахад чиглэсэн зохион байгуулалтыг заавал хийх шаардалгатай гэж дүгнэж байна.

3.4. 2025 онд шинээр байгуулах “Санамж бичиг”-т өмнөх оны хэрэгжилт хангалтгүй болон удаашралтай байгаа арга хэмжээг тусгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх хугацаа 2024 онд дууссан тул шинээр байгуулах “Санамж бичиг”-т Нийслэлийн болон яамны хийх ажил, үйлчилгээний зааг ялгааг тусган төлөвлөх, салбарын бодлогын уялдааг хангуулах, хууль эрх зүй, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх чиглэлээр яам ажиллах, харин бүтээн байгуулалт болон тэдгээрийг хэрэгжүүлтийг бүрэн хангуулах чиглэлээр Нийслэлийн харьяа байгууллагууд ажиллах шаардлагатай байна.

4.2. “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулахад зорилтод түвшинг улирал бүрээр, шалгуур үзүүлэлтийг зорилтод түвшинтэй уялдуулж, хэмжигдэхүйц төлөвлөх, төлөвлөгөөний төслийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраар хянуулж, саналыг тусгаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

4.3. “Санамж бичиг”-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар Нийслэлийн Засаг даргын харьяа холбогдох газар, албан тушаалтнуудыг оролцуулсан уулзалт, ярилцлага зохион байгуулах, үр дүнг улирал бүр хэлэлцүүлэх, хэрэгжилтийг тайлагнахад хамтран ажиллах;

4.4. Төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээний биелэлтийн тайлан, мэдээ гаргахдаа тодорхой тоо баримттай, өссөн буурсан хувь хэмжээг суурь үзүүлэлтүүд болон чанарын үзүүлэлтүүдтэй харьцуулан, дэс дараалалтай тайлагнахад анхаарч ажиллахыг тус тус зөвлөж байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ НАР ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 2021-2024 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАХААР БАЙГУУЛСАН “САНАМЖ БИЧИГ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨНД 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

**"Санаж бичиг"-ийг хэрэгжүүлэх 2024 оны
төлөвлөгөөний хэрэгжилт**

